



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Алтанцэгцүүхэй” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/231/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 11315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер: С.Гантөгс  
Утас: 11315558 Цахим хаяг: [gantugss@audit.gov.mn](mailto:gantugss@audit.gov.mn)  
“Ворлдвайд файнэнс Аудит” ХХК-ийн захирал: С.Оюунгэрэл  
Утас: 99032466 Цахим хаяг: [oyungerels.sag@gmail.com](mailto:oyungerels.sag@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024-05-13 № 862  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН  
ДҮҮРГИЙН "АЛТАНЦЭГЦҮҮХЭЙ"  
ӨЭМТ-ИЙН ДАРГА Б.ХУЛАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Алтанцэгцүүхэй" ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Алтанцэгцүүхэй" ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Алтанцэгцүүхэй" ӨЭМТ нь 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд оногдох зардлын санхүүжилтээр 678.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчин бүрдсэн байна. Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

1426050471

C:\Users\aranga\Desktop\audit\_report\_2024\0726\0726050471.docx

### **Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Алтанцэгцүүхэй ӨЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 28-аар баталж, тайлант онд 20 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	103,155.97	19,473,306.96
Дансны авлага	58,827,884.65	7,583,426.80
Бараа материал	98,696,676.00	86,320,873.94
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>157,627,716.62</b>	<b>113,377,607.70</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	127,133,129.45	98,109,903.52
Биет бус хөрөнгө	21,083.29	10,083.25
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>127,154,212.74</b>	<b>98,119,986.77</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>284,781,929.36</b>	<b>211,497,594.47</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
Богино хугацаат өр төлбөр		
<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>40,068,994.00</b>	<b>40,068,994.00</b>
Төрийн	40,005,994.00	40,005,994.00
Хувийн	63,000.00	63,000.00
Хуримтлагдсан ашиг	244,712,935.36	171,428,600.47
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>284,781,929.36</b>	<b>211,497,594.47</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>284,781,929.36</b>	<b>211,497,594.47</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Борлуулалтын орлогын дүн</b>		
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
<b>Нийт ашиг (алдагдал)</b>		
Бусад орлого	724,351,376.68	678,285,104.14
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	704,512,069.73	751,569,439.03
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>19,839,306.93</b>	<b>-73,284,334.89</b>
Орлогын татварын зардал		
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>19,839,306.93</b>	<b>-73,284,334.89</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>19,839,306.93</b>	<b>-73,284,334.89</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</b>	<b>678,335,026.05</b>	<b>729,118,833.99</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	678,335,026.05	729,118,833.99
Буцаан авсан албан татвар		76,858.76
Татаас, санхүүжилтийн орлого	678,220,026.05	728,921,975.23
Бусад мөнгөн орлого	115,000.00	120,000.00
<b>Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн</b>	<b>666,299,078.99</b>	<b>700,677,783.00</b>
Ажиллагчдад төлсөн	505,681,309.22	525,949,866.64
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	51,637,839.72	53,174,292.42
Бараа материал худалдан авахад төлсөн	84,859,054.20	57,996,181.66
Ашиглалтын зардалд төлсөн	10,526,267.20	11,156,856.41
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Бусад мөнгөн зарлага	13,594,608.65	52,400,585.87
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>12,035,947.06</b>	<b>28,441,050.99</b>
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>	<b>80,000.00</b>	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	80,000.00	
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>12,155,800.00</b>	<b>9,070,900.00</b>
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,155,800.00	9,070,900.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(12,075,800.00)</b>	<b>(9,070,900.00)</b>
<b>Санхүүгийн мөнгөн гүйлгээ</b>		
<b>Санхүүгийн мөнгөн орлогын дүн</b>		
<b>Санхүүгийн мөнгөн зарлагын дүн</b>	-	-
<b>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(39,852.94)</b>	<b>19,370,150.99)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>143,008.91</b>	<b>103,155.97</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>103,155.97</b>	<b>19,473,306.96</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>39,953,994.00</b>	-	-	-	-	<b>224,873,628.41</b>	<b>264,827,622.41</b>
Зарласан ногдол ашиг		.				-	-
Өмчит гарсан өөрчлөлт					-		
Тайлант үеийн ашиг	115,000.00					19,839,306.95	19,954,306.95
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>40,068,994.00</b>	-	-	-	-	<b>244,712,935.36</b>	<b>284,781,929.36</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт						-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>		-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг		.				-	-
Өмчит гарсан өөрчлөлт					-		-
Тайлант үеийн ашиг						-73,284,334.89	-73,284,334.89
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>40,068,994.00</b>	-	-	-	-	<b>171,428,600.47</b>	<b>211,497,594.47</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 74,553.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Тайлант хугацаанд санхүүгийн байдлын тайлан дахь Төрийн өмчийн дүнг 105.0 мянган төгрөгөөр бууруулсныг залруулав.
- Машин тоног төхөөрөмжид бүртгэлтэй 74,448.8 мянган төгрөгийн дүн бүхий 58 ширхэг компьютер бусад хэрэгслийг "компьютер бусад хэрэгсэл"-д ангилан бүртгүүлж, алдааг залруулсан.

Эдгээр нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга-ын 15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой.", НББОУС 16: Үндсэн хөрөнгө "үндсэн хөрөнгийн анги тус бүрийн ... тайлант хугацааны өөрчлөлтийг тодруулна", Сангийн сайдын 2017 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын "Компьютер, бусад хэрэгсэл-ийг ангилан бүртгэнэ" гэсэн заалтууд болон санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,600.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 1 албан шаардлага өгсөн.

Залруулагдаагүй 1,600.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 2,876.9 мянган төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

Эрүүл мэндийн даатгалын багцын тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанартай хүргэж гүйцэтгэх ажил нь ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хувьд хамааралгүй байхад ӨЭМТ-ийн даргын 9 удаагийн тушаалаар Нягтлан бодогч Т.Жаргалмаа нийт 1,600.0 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3.1.7 "...эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц гэж даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх болон эмийн үнийн хөнгөлөлтийг багтаасан эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг" гэсэн заалт болон санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нийцүүлэн урамшууллыг олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Алтанцэгцүүхэй ӨЭМТ-ийн 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн байдлын тайлан дахь Засгийн газрын хувь оролцооны Төрийн өмчийн дүн оны эхэнд 40,005,994 төгрөг байсныг оны эцэст 39,900,994 төгрөг болгож бууруулсан байлаа.	1	105.0			1	105.0	1	105.0				
Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 58 ширхэг компьютер бусад хэрэгслийг "компьютер бусад хэрэгсэл"-д ангилан бүртгээгүй, машин, тоног төхөөрөмж ангилалд бүртгэсэн.	1	74,448.8			1	74,448.8	1	74,448.8				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>74,553.8</b>			<b>1</b>	<b>74,553.8</b>	<b>1</b>	<b>74,553.8</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрүүл мэндийн даатгалын багцын тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанартай хүргэж гүйцэтгэх ажил нь ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хувьд хамааралгүй байхад ӨЭМТ-ийн даргын 9 удаагийн тушаалаар Нягтлан бодогч Т.Жаргалмаа нийт 1,600.0 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.	1	1,600.0			1	1,600.0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,600.0</b>			<b>1</b>	<b>1,600.0</b>		

